

“Миг даатгал” ХХК-ийн 2022 оны 01/11-445 тоот хүсэлтэд үндэслэн гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах “Гийнгоо” хурдан морины уралдаанч хүүхдийн даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэв.

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2022	Сар	04	Өдөр	22
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	МИГ Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	“Гийнгоо” хурдан морины уралдаанч хүүхдийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Гүйцэтгэх захирлын тушаал		2022.04.22		А/21-481	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Чулуунбаатар		Баттүшиг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	<input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	7-18 хүртэлх насны хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд.					
	Даатгалын үндсэн эрсдэл	<ol style="list-style-type: none"> 1. Улсын болон орон нутгийн шинж чанартай морины уралдаан, түүний бэлтгэл, сунгаан, хурдан морь сойх, тарлах үеийн гэнэтийн осол; 2. Хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үе р усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн эрсдэлийн улмаас гэнэтийн осолд өртөх; 3. Юманд цохиулах, хавчигдах, хавчуулах, хальтрах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох, наранд цохиулах, угаартах, хоолны хордлого, хорт хий, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан шавьжинд өртөх зэрэг ахуйн эрсдэл; 4. Мал маллагаа, амьтдын нөлөөллийн улмаас мал, амьтнаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах зэргээр гэнэтийн осолд өртөх; 5. Автомашин, мотоцикл, унадаг дугуй, механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн 					

		хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг техниктэй харьцах, ашиглах үед гэнэтийн осолд өртөх; 6. Зам тээврийн ослын улмаас гэнэтийн осолд өртөх.
	Даатгалын нэмэлт эрсдэл	-
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,5%